

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү ногдол ашгийн бодлого (цаашид “Бодлого” гэх) нь “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компани (цаашид “МХБ” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашиг олгох, түүнийг тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Бодлого нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журамд нийцсэн байх ба МХБ-ийн ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд мөрдлөг болгоно.

1.3. Бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эрх гагцхүү МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-д хадгалагдана.

1.4. МХБ нь Бодлогыг өөрийн цахим хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгох ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээдэд танилцах боломж олгоно.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

2.1. МХБ-ийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт зааснаар МХБ-ээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналаа ТУЗ-д бичгээр гаргана.

2.2. МХБ нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

- 2.2.1. тухайн санхүүгийн жилд ашигтай ажилласан байх;
- 2.2.2. ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх;
- 2.2.3. ногдол ашиг төлсний дараа өөрийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн хуулийн 30.5-д¹ заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
- 2.2.4. эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;
- 2.2.5. жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтад зарцуулах дүнг хасаад үлдэх хэсгээс ногдол ашиг хуваарилах. Энэхүү хөрөнгө оруулалтад хуваарилах дүн нь цэвэр ашгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

2.3. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

¹ 30.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна.

2.4.МХБ нь эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

Гурав. Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр

3.1.ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.2.ТУЗ нь төрийн эрх бүхий байгууллагаас ногдол ашгийн талаар гаргасан шийдвэр, Бодлогын 2.1-д заасан санал, Бодлогын 2.2-т заасан нөхцөл болон МХБ-ийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг хэвийн хэмжээнд хэрэгжүүлэх нөхцөлийг харгалзан тухайн жилд хуваарилах эсэх, хуваарилах тохиолдолд ногдол ашгийн хэмжээг тогтооно.

3.3.ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол үндэслэл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлант жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.

3.4.Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хэлбэрээр хуваарилах бөгөөд бэлэн мөнгө болон эд хөрөнгө, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

3.5.ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгана.
Үүнд:

- 3.5.1. нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ;
- 3.5.2. ногдол ашиг төлөх хугацаа;
- 3.5.3. ногдол ашиг төлөх хэлбэр;
- 3.5.4. ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдөр буюу бүртгэлийн өдөр;
- 3.5.5. шаардлагатай бусад.

3.6.Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

3.7.Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааварт нийцсэн байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, төлөх, тайлагнах, мэдээлэх

4.1.Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-ийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

4.2.ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг МХБ-ийн цахим хуудсанд байршуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

4.3.ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрөөр тасалбар болгож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй хуулгыг гаргуулна.

4.4. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах тохиолдолд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн дансанд байршуулна.

4.5. МХБ-ийн ногдол ашиг хуваарилалтын тайланг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 (арван тав) өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

4.6. МХБ нь өөрийн жилийн тайланд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэхүү журмын дагуу тайлбарласан байна.

Тав. Бусад зүйл

5.1. МХБ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.

5.2. МХБ нь ногдол ашгаа Бодлогын 5.1-д заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хожимдуулсан хоног тутам төлбөл зохих дүнгийн 0.5 хувиар тооцож, хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс МХБ-д учирсан хохирлыг МХБ-ийн гүйцэтгэх удирдлага нөхөн төлнө.

5.3. ТУЗ-ийн тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

5.4. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.